ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сум Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2024 он	Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn Аудитын менежер :Х.Болдбаатар Утас:99105506 Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn Аудитор: Д.Пүүжмаа Утас:99080797 Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
4.1 Ерөнхий зүйл .....
4.2 Материаллаг байдал .....
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.03.14 № 226

танай _____ -ны № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Д.ГАНЦООЖ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлан баталгаажуулах аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 383.0 сая төгрөгийн хог шатаах зуух, Тосонцэнгэл сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаас 77.3 сая төгрөгөөр 2 автомашин, 51.7 сая төгрөгийн өртөг бүхий гэрэлтүүлгийг данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар хог хаягдлын хураамжийн орлогыг төвлөрүүлж ажиллаагүй, газрын цахим мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 2 газрын гэрчилгээ, бичиг баримтыг холбогдох газруудаар гаргуулж данс бүртгэлд тусгаагүй, элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 2 ширхэг авто тээврийн хэрэгслийг дээд газартаа уламжлан шийдвэрлүүлээгүй, цалин амралтын мөнгийг давхардуулан олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

013020390

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс 143.3 сая, Тарвагатай нурууны байгалийн цогцолборт газраас 15.0 сая, Идэр голын сав газрын захиргаанаас 15.0 сая, өөрийн орлогоор 19.1 сая төгрөгийг бүрдүүлэн, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	9,055.47	6,256,344.39
1.1.2	Дансны авлага	-	750,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	707,070.45	707,070.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,000,000.00	2,000,000.00
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**2,716,125.92**	**9,713,414.84**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	95,392,672.00	565,358,337.03
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**95,392,672.00**	**565,358,337.03**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**98,108,797.92**	**575,071,751.87**
2.1.1.1	Дансны өглөг	2,974,595.97	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	(0.00)
2.1.1.3	Татварын өр	79,795.75	0.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,063,491.72	(0.00)
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**4,117,883.44**	**(0.00)**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**4,117,883.44**	**(0.00)**
2.3.2	хувийн	129,280,000.00	644,507,005.00
2.3.3	хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	-
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(35,289,085.52)	(69,435,253.13)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**93,990,914.48**	**575,071,751.87**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**98,108,797.92**	**575,071,751.87**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01-р сарын 01	12-р сарын 31
1	**Борлуулалтын орлого (цэвэр)**	132,172,850.00	**99,877,680.55**
2	Борлуулалтын өртөг		-
3	**Нийт ашиг (алдагдал)**	**132,172,850.00**	**99,877,680.55**
4	Түрээсийн орлого		-
5	Хүүний орлого		-
6	Ногдол ашгийн орлого		-
7	Эрхийн шимтгэлийн орлого		-
8	Бусад орлого		607,355,005.00
8	*Бусад орлого (Татвар ногдох орлого)*		93,338,000.00
81	*Бусад орлого (Татвар ногдохгүй орлого)*		514,017,005.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	122,279,497.28	227,361,848.16
11	Санхүүгийн зардал	317,400.00	-
12	Бусад зардал	38,458,400.00	514,017,005.00
30	*Бусад зардал (татвар ногдох орлогоос хасагдах зардал)*		514,017,005.00
300	*Бусад зардал (татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал)*		-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
17	Бусад ашиг (алдагдал)		-
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**(28,882,447.28)**	**(34,146,167.61)**
19	Орлогын татварын зардал		-
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**(28,882,447.28)**	**(34,146,167.61)**
21	**Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)**		-
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**(28,882,447.28)**	**(34,146,167.61)**
23	**Бусад дэлгэрэнгүй орлого**	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
	Бусад олз (гарз)		-
24	**Орлогын нийт дүн**	**(28,882,447.28)**	**(34,146,167.61)**
25	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл**	**129,280,000.00**	**(35,289,085.52)**	**93,990,914.48**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	**-**
3	**Залруулсан үлдэгдэл**	**129,280,000.00**	**(35,289,085.52)**	**93,990,914.48**
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(34,146,167.61)	**(34,146,167.61)**
5	Бусад дэлгэрэнгүй орлого			**-**
6	Өмчид гарсан өөрчлөлт	515,227,005.00		**515,227,005.00**
7	Зарласан ногдол ашиг			**-**
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			**-**
9	**2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл**	**644,507,005.00**	**(69,435,253.13)**	**575,071,751.87**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	01-р сарын 01	12-р сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	**132,172,850.00**	**192,465,680.55**
111	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	132,150,850	99,127,680.55
112	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
113	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-
114	Буцаан авсан албан татвар		-
115	Татаас, санхүүжилтийн орлого		-
116	Бусад мөнгөн орлого	22,000	93,338,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**131,946,256.29**	**181,151,909.63**
121	Ажиллагчдад төлсөн	44,038,967	53,761,210.20
122	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,040,655	18,658,620.66
123	Бараа материал худалдан авахад төлсөн	6,073,800	26,299,500.00
124	Ашиглалтын зардалд төлсөн	3,926,364	4,853,170.00
125	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	26,997,057	31,887,798.00
126	Хүүний төлбөрт төлсөн		-
127	Татварын байгууллагад төлсөн	3,151,588	4,561,910.77
128	Даатгалын төлбөрт төлсөн	357,795	-
129	Бусад мөнгөн зарлага	34,360,030	41,129,700.00
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**226,593.71**	**11,313,770.92**
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**700,000.00**	**-**
221	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700,000	-
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(700,000.00)**	**-**
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**-**	**5,066,482.00**
311	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		5,066,482.00
322	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
323	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		-
324	Төлсөн ногдол ашиг		-
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	-	**(5,066,482.00)**
331	**валютын ханшийн зөрүү**		-
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	(473,406.29)	**6,247,288.92**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**482,462**	**9,055.47**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**9,055**	**6,256,344.39**

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ нь Тосонцэнгэл сумын гэрэлтүүлэг, гудамжны хог цэвэрлэгээ, айл өрх албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг тээвэрлэж хогийг цэгт хүргэн, ард иргэдийг хоггүй цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 51 дугаар тогтоолоор 5 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Ингэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоогоогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж

ахуйн нэгжид мөрдөгдөх ”Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 469.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.0	6,256.3	6,247.3
Авлага	707.1	707.1	0
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	95,382.7	565,358.3	469,965.6
Нийт хөрөнгө	**98,108.8**	**575,071.7**	**476,962.9**
Өр төлбөр	4,117.9	0	-4,117.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	93,990.9	575,071.7	481,080.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**4,367,586.7**	**4,189,872.3**	**-177,714.4**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 469.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хог шатаах зуух, өөрийн хөрөнгөөр худалдан авсан пос машиныг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны цалин НДШ, байгууллагад төлөх өглөгийн барагдуулж ажилласан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд тээвэр шатахууны зардал хэмнэгдсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ нь 2023 оны зорилтот түвшний төсвийн төлөвлөгөө, хуваарь гаргаж дээд шатны байгууллагаар батлуулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайланд онд тус байгууллага нь орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөг, хог хагдлын хураамжаас 19.1 сая төгрөг, ОНХС-аас 54.0 сая төгрөг, Идэр голын сав газрын захиргаа, Тарвагатай нурууны байгалын цогцолборт газрын захиргаанаас 30.0 сая төгрөгийг авч, ерөнхий ба удирдлагын зардалд 181.1 сая төгрөг, бусад

зардалд 5.2 сая төгрөг зарцуулж, мөнгөн хөрөнгө дансанд 6.2 төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, явцын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсувд, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт орлогын 132.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	500.0	4	500.0	100
Нийт дүн	**4**	**500.0**	**4**	**500.0**	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 412,210.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулаа.

Үүнд: 384,210.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 28,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тооцоолсон алдааг санхүүгийн тайланд нь залруулаа.

Аудитаар нийт 645.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 645.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

645.0 мянган төгрөгийн цалин амралтын мөнгийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.10.Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.9.Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох нөхцөл үүсээгүй байгаа бол түүний ээлжийн амралтыг ажлын нэг жилээр тооцож олгоно, 3.4.Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно гэж заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал холбоотой асуудал

Илрүүлэлт: *Газрын цахим мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 2 газрын, гэрчилгээ, бичиг баримтыг холбогдох газруудаар гаргуулж данс бүртгэлд тусгаагүй нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: *Газрын цахим мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 2 газрын, гэрчилгээ, бичиг баримтыг холбогдох газруудаар гаргуулж данс бүртгэлд тусгах*

Илрүүлэлт: *Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 2 ш авто тээврийн хэрэгслийг дээд газартаа уламжлан шийдвэрлээгүй нь НББ-ийн тухай хуулийг зөрчсөн байна*

Өгсөн зөвлөмж*: Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 2 ш авто тээврийн хэрэгслийг дээд газартаа уламжлан актлуулах*

Илрүүлэлт: *Хог хаягдлын хураамжийн орлогыг төвлөрүүлж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна*

Өгсөн зөвлөмж*:Хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу хураамжийг төвлөрүүлж ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Пос төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй	1	1,210.0	1	1,210.0			1	1,210.0				
Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хог хаягдал шатаах зуухыг бүртгэлд тусгаагүй	1	383,000.0	1	383,000.0			1	383,000.0				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тооцоолсон	1	28,000.0			1	28,000.0	1	28,000.0				
Дүн	**3**	**412,210.0**	**2**	**384,210.0**	**1**	**28,000.0**	**3**	**412,210.0**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын цахим мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 2 газрын, гэрчилгээ, бичиг баримтыг холбогдох газруудаар гаргуулж данс бүртгэлд тусгаагүй	1	0					1	0				
Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 2 ш авто тээврийн хэрэгслийг дээд газартаа уламжлан шийдвэрлээгүй	1	0					1	0				
Хог хаягдлын хураамжийн орлогыг төвлөрүүлж ажиллаагүй	1						1	0				
Цалин амралтын мөнгийг давхардуулан олгосон	1	645.0	1	645.0								
Дүн	**4**	**645.0**	**1**	**645.0**			**3**	**0**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								